



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/35

Хэрлэн сум

### Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 7.6 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг байгуулагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгосугай.

2. Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ө.Алимаа)-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсролын газрын дарга (С.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



